

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/85/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www. Shinjlenmagadlahui
ezsh.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас: 70373089, 99023682
Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn
Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит
ХХК
Утас: 99197346, 88114867 Цахим хаяг:
Shinjlenmagadlahui.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	
5.2 Албан шаардлага	
5.3 Зөвлөмж	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ
СУМЫН 19 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.САРУУЛ ТАНАА**

2025.02.25 № 87

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэгийн 2024 оны нийт төсвийн зарцуулалт тус байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 87.8 хувийн биелэлттэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус цэцэрлэгийн цалингийн зардал

4525020151

өнгөрсөн оны гүйцэтгэлээс 187,952.2 мянган төгрөгөөр буюу 66.7 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 13 зорилт, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 91.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

/төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан


Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>108,416,279.05</u>	<u>172,857,351.88</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	67,857,192.05	79,036,774.88
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	67,857,192.05	79,036,774.88
3121	Төгрөг	67,857,192.05	79,036,774.88
31211	Төрийн сангийн харилцах	67,857,192.05	79,036,774.88
35	БАРАА МАТЕРИАЛ	40,559,087.00	93,820,577.00
351	Түүхий эд материал	983,600.00	615,550.00
35130	Эм боох материал	983,600.00	615,550.00
354	Хангамжийн материал	39,575,487.00	93,205,027.00
35410	Бичиг хэргийн материал	1,818,000.00	1,680,480.00
35420	Аж ахуйн материал	31,452,207.00	83,422,127.00
35450	Барилгын засварын материал	657,900.00	2,878,700.00
35460	Хүнсний материал	5,647,380.00	5,223,720.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>878,526,254.29</u>	<u>913,545,000.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	878,526,254.29	913,545,000.09
392	Биет хөрөнгө	871,126,254.09	906,145,000.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	899,886,999.60	899,886,999.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,934,568.20)	(71,912,757.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,496,362.00	66,564,280.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,211,769.16)	(28,385,177.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,406,779.16	15,553,779.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,069,316.94)	(10,510,441.37)
39209	Зам, гүүрийн байгууламж	16,445,512.63	22,445,512.63
39210	Хуримтлагдсан элэгдэл	(4,943,745.00)	(6,072,194.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	19,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(474,999.99)
39217	Ном	50,000.00	50,000.00
393	Биет бус хөрөнгө	7,400,000.20	7,400,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,299.80)	(-1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,400,000.00	7,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>986,942,533.34</u>	<u>1,086,402,351.97</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>986,942,533.34</u>	<u>1,086,402,351.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	986,942,533.34	1,086,402,351.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,400,000.00	7,400,000.00
51101	Өмч: - төрийн	7,400,000.00	7,400,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	978,226,848.69	1,077,686,667.32
51210	Өмнөх үеийн үр дүн	978,226,848.69	978,226,848.69
51220	Тайлант үеийн үр дүн	30,720,521.99	99,459,818.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,315,684.65	1,315,684.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>986,942,533.34</u>	<u>1,086,402,351.97</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	493,876,500.00	785,203,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	116,467,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	116,467,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	11,306,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	6,306,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	58,631,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	46,530,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	493,876,500.00	668,736,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	427,312,500.00	601,936,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	427,312,500.00	601,936,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,564,000.00	66,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,564,000.00	66,800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	463,155,978.01	685,743,681.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,155,978.01	685,743,681.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,137,167.37	685,714,509.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,768,292.56	469,720,502.27
210101	Үндсэн цалин	205,498,491.38	303,543,700.92
210102	Нэмэгдэл	61,580,281.40	152,147,576.30
210104	Урамшуулал	14,689,519.78	14,029,225.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,887,914.79	59,220,634.90
210201	Тэтгэврийн даатгал	24,906,414.50	41,118,959.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,930,166.38	4,724,374.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,273,733.16	2,319,287.27
210204	Ажилгүйдлийн даатгал	517,626.59	2,166,342.75
210205	Эрүүл мэндийн даатгал	5,259,974.16	8,891,671.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,113,689.36	49,114,827.91
210301	Гэрэл, цахилгаан	5,443,623.61	7,259,291.91
210302	Түлш, халаалт	35,065,704.31	33,534,357.72
210303	Цэвэр, бохир ус	7,604,361.44	8,321,178.28
2104	Хангамж, бараа материалын зардал	1,594,850.00	2,543,680.00
210401	Бичиг хэрэг	577,850.00	737,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	153,760.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	863,240.00	1,806,680.00
2105	Нормативт зардал	39,190,700.00	44,051,190.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	600,950.00
210502	Хоол, хүнс	39,190,700.00	43,450,240.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,785,700.00	16,318,900.00
210604	Урсгал засвар	18,785,700.00	16,318,900.00
2107	Томилолт, зочны зардал	104,000.00	-
210702	Дотоод албан томилолт	104,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	780,000.00	1,000,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	780,000.00	1,000,500.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,912,020.66	43,744,274.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,257,600.00	6,237,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,179,400.00	4,587,820.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,475,020.66	32,918,554.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,810.64	29,172.09
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,810.64	29,172.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,810.64	29,172.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	30,720,521.99	99,459,818.63



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>493,876,500.00</u>	<u>673,736,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	<u>5,000,000.00</u>
120	НИЙТЛЭГ ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	<u>5,000,000.00</u>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	<u>5,000,000.00</u>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	<u>5,000,000.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	493,876,500.00	668,736,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	427,312,500.00	601,936,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	427,312,500.00	601,936,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,564,000.00	66,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,564,000.00	66,800,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>435,148,707.35</u>	<u>659,556,617.17</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,148,707.35	659,556,617.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,129,896.71	659,527,445.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,768,292.56	469,720,502.27
210101	Үндсэн цалин	205,498,491.38	303,543,700.92
210102	Нэмэгдэл	61,580,281.40	152,147,576.30
210104	Урамшуулал	14,689,519.78	14,029,225.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,887,914.79	59,220,634.90
210201	Тэтгэврийн даатгал	24,906,414.50	41,118,959.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,930,166.38	4,724,374.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,273,733.16	2,319,287.27
210204	Ажилгүйдлийн даатгал	517,626.59	2,166,342.75
210205	Эрүүл мэндийн даатгал	5,259,974.16	8,891,671.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,113,689.36	49,114,827.91
210301	Гэрэл, цахилгаан	5,443,623.61	7,259,291.91
210302	Түлш, халаалт	35,065,704.31	33,534,357.72
210303	Цэвэр, бохир ус	7,604,361.44	8,321,178.28
2105	Нормативт зардал	37,664,800.00	43,026,580.00
210502	Хоол, хүнс	37,664,800.00	43,026,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,431,500.00	17,656,000.00
210604	Урсгал засвар	18,431,500.00	17,656,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	718,800.00	1,910,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	718,800.00	1,910,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,544,900.00	18,878,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,388,500.00	13,368,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,156,400.00	5,510,100.00
00213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,810.64	29,172.09

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,810.64	29,172.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,810.64	29,172.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>58,727,792.65</u>	<u>14,179,382.83</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,999,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,999,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,599,800.00
223001	Бусад хөрөнгө	-	400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>2,999,800.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	58,727,792.65	11,179,582.83
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,129,399.40	67,857,192.05
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,857,192.05	79,036,774.88



 ХТ05430-8 9022699

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	7,400,000.00	1,315,684.65	947,506,326.70	956,222,011.35
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	30,720,521.99	30,720,521.99
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,400,000.00	1,315,684.65	978,226,848.69	986,942,533.34
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,400,000.00	1,315,684.65	978,226,848.69	986,942,533.34
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	99,459,818.63	99,459,818.63
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,400,000.00	1,315,684.65	1,077,686,667.32	1,086,402,351.97

ХТ05438@8022899

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	754,562,400.00	662,556,417.17	(92,005,982.83)	87.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	754,562,400.00	662,556,417.17	(92,005,982.83)	87.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	754,562,400.00	662,527,245.08	(92,035,154.92)	87.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	536,047,100.00	469,720,502.27	(66,326,597.73)	87.63
210101	Үндсэн цалин	357,333,400.00	303,543,700.92	(53,789,699.08)	84.95
210102	Нэмэгдэл	169,770,500.00	152,147,576.30	(17,622,923.70)	89.62
210104	Урамшуулал	8,943,200.00	14,029,225.05	5,086,025.05	156.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,459,000.00	59,220,634.90	(4,238,365.10)	93.32
210201	Тэтгэврийн даатгал	43,153,000.00	41,118,959.26	(2,034,040.74)	95.29
210202	Тэтгэмжийн даатгал	5,075,900.00	4,724,374.59	(351,525.41)	93.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,538,300.00	2,319,287.27	(219,012.73)	91.37
210204	Ажилгүйдлийн даатгал	2,538,300.00	2,166,342.75	(371,957.25)	85.35
210205	Эрүүл мэндийн даатгал	10,153,500.00	8,891,671.03	(1,261,828.97)	87.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,113,300.00	49,114,827.91	(12,998,472.09)	79.07
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	7,259,291.91	1,259,291.91	120.99
210302	Түлш, халаалт	48,113,300.00	33,534,357.72	(14,578,942.28)	69.70
210303	Цэвэр, бохир ус	8,000,000.00	8,321,178.28	321,178.28	104.01
2105	Нормативт зардал	49,437,500.00	43,026,580.00	(6,410,920.00)	87.03
210502	Хоол, хүнс	49,437,500.00	43,026,580.00	(6,410,920.00)	87.03
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,656,000.00	17,656,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	17,656,000.00	17,656,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,910,500.00	1,910,500.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,910,500.00	1,910,500.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,939,000.00	21,878,200.00	(2,060,800.00)	91.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,428,900.00	16,368,100.00	(2,060,800.00)	88.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,510,100.00	5,510,100.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		29,172.09		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох		29,172.09		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		29,172.09		



1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	754,562,400.00	673,736,000.00	(80,826,400.00)	89.29
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	669,793,100.00	601,936,000.00	(72,857,100.00)	89.20
131001	Улсын төсвөөс санхүүжих	669,793,100.00	601,936,000.00	(67,857,100.00)	89.86
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	79,769,300.00	66,800,000.00	(12,998,472.09)	83.70
132001	Орон нутгийн төсвөөс	79,769,300.00	66,800,000.00	(12,998,472.09)	83.70
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	5,000,000.00		100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000.00		100.00
31	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	67,857,192.05	67,857,192.05	
31	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	79,036,774.88	79,036,774.88	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
3	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	-	100.00
6	Удирдах ажилтан	1	1	-	100.00
7	Гүйцэтгэх ажилтан	14	14	-	100.00
8	Үйлчлэх ажилтан	6	6	-	100.00
9	Гэрээт ажилтан	2	2	-	100.00
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	138.0	138.0		100.00
11	Төрийн өмчит СӨБ байгууллага	1	1		100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

“Суралцагчийн танин мэдэхүй, эрүүл мэнд, нийгэм-сэтгэл хөдлөлийг хөгжүүлэх бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж сургалтын үйл ажиллагааны чанар үр дүнг сайжруулах зорилгыг тавьж энэхүү зорилгыг хангах чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

1. Багш бүр хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нийцүүлэн зураг дүрс, тэмдэгт мэдээллийн утга санааг ойлгох, унших, илэрхийлэх, тайлбарлах чадварыг өдөр тутмын сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэгжүүлэх;
2. Суралцахуйг дэмжих, тэдний онцлог хэрэгцээнд суурилан хөгжлийн дэмжлэгийг чанар үр дүнтэй үзүүлэхэд талуудын оролцоо, хамтын ажиллагааг идэвхжүүлэх
3. Багш ажилчдын хэрэгцээ сонирхол, үнэлгээ судалгаанд үндэслэн сургалтуудыг зохион байгуулан онол арга зүйн мэдлэг чадамжийг сайжруулах замаар чадавхжуулах
4. Гамшиг, болзошгүй аюул эрсдлийн үед бэлэн байдлаа хангах мэдлэг чадвар, дадал хэвшилтэй болоход багш ажилчдад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран үр дүнтэй зохион байгуулах
5. Шимт боловсрол буюу STEAM хөтөлбөрийг хэрэгжүүлж “үйлдэн суралцах” арга зүйгээр хүүхдүүдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, эерэг хандлага, ёс зүйг төлөвшүүлэх замаар тэдний боловсрол эзэмших суурь чадамжийг цэгцтэй, бүтээмжтэй, хүртээмжтэйгээр олгох,
6. “Өдөр бүр сүү” арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжин ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны тогтоол 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоол "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн байна.
- Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 238 дугаар тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тогтоолоор батлагдсан дундаж цалин хөлс тодорхойлох журмыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоол "Орон нутгийн нэмэгдэлд өөрчлөлт оруулах тухай". 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосныг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.
- Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/52 "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.
- Монгол улсын сангийн сайдын 211 дүгээр тушаал "Эдийн засгийн ангилал шинэчлэн батлах тухай" 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.
- Шинэчлэн найруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал байна гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон 2021 онд

боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99,459.8 мянган төгрөгөөр буюу 10,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	67,857.2	79,036.8	11,179.6
Бараа материал	40,559.1	93,820.6	53,261.5
Үндсэн хөрөнгө	878,526.3	913,545.0	35,018.8
Нийт хөрөнгө	986,942.5	1,086,402.3	99,459.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	986,942.5	1,086,402.3	99,459.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	986,942.5	1,086,402.3	99,459.8

Улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 79,036.7 мянган төгрөг байгаа нь тайлант онд 674,793.1 мянган төгрөгийн санхүүжилт орж тухайн байгууллагын цалингийн сангаас 66,326.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,238.4 мянган төгрөг, хүүхдийн хоол хүнсний зардлаас 6,410.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 2,060.8 мянган төгрөг хэмнэж Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолоор "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна. Орон нутгийн төсөв тайлант онд 79,769.3 мянган төгрөгний төлөвлөгөөтэй байснаас 66,800.0 мянган төгрөгний дутуу санхүүжилт олгогдож байр ашиглалт болон урсгал засвараас 66,770.8 мянган төгрөгний гүйцэтгэл гарч 29,1 мянган төгрөгийн төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 93,820.6 мянган төгрөг болж 53,261.5 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 46,530.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 75,751.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 69,020.5 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 913,545.0 мянган төгрөг болж 35,018.8 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 58,631.5 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 2,999.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 13,722.4 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан нь шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,086,402.35 мянган төгрөг болж 99,459.82 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 674,793.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 79,769.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 754,562.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2024 оны 12 дугаар сард цалингийн зардалд 41,822.7 мянган төгрөгийг, хүүхдийн хоол хүнсний зардалд 1,275.1 мянган төгрөг мөн бусад зардалд нийт 46,105.4 мянган төгрөгөөр төсвийг нэмж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 606,936.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 66,800.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Төсвийн нийт орлогын гүйцэтгэл 673,736.0 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9 арга хэмжээний зардалд нийт 662,556.4 мянган төгрөг буюу 98.3 хувь байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	80233-Хүүхэд хамгаалал	853.7	853.7		100	
2	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,259.1	934.0	325.1	74.1	
3	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	49,437.5	43,026.6	6,410.9	89.5	
4	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,435.0	2,435.0	-	100	
5	81823- Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,259.1	850.0	409.1	67.5	
6	81834- Боловсролын стандарт сургалт	611,209.1	541,122.7	70,086.4	88.5	
7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	3,339.6	1,534.4	1,805.2	45.9	
8	83603- Дээд шатны төсвөөс хуваарилсан	5,000.0	5,000.0	-	100	
9	80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	79,769.3	66,800.0	12,969.3	83.7	
		754,562.4	662,556.4	92,006.0	87.8	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

2024 онд орон тоо 20 төлөвлөсөн. Эрхлэгчийн 2024 оны Б/33 тоот тушаалаар 3 орон тоо нэмэгдсэн. Гүйцэтгэлээр 23 оронтой ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу нийт 171 мэдээ нийтэд мэдээлэхээс 170 мэдээлэл хугацаанд нь мэдээллэсэн. Хугацаа хоцорсон 1 мэдээлэл байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 5 бараа, ажил үйлчилгээний зардал 75,287.0 мянган төгрөг батлагдсанаас 5 бараа, ажил үйлчилгээний зардалд 61,494.3 мянган төгрөгийг шууд худалдан авалт, 1 бараа, ажил үйлчилгээний зардалд 5,321.0 мянган төгрөгийг ерөнхий гэрээгээр зохион байгуулсан байна. 2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад хүүхдийн хоол хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажилласан байна. Хүүхдийн хоол хүнс худалдан авах нээлттэй тендер

шалгаруулалтыг тайлант онд Дархан-Уул аймгийн Боловсролын газраас нэгдсэн тендер зарлаж ерөнхий гэрээний дагуу худалдан авалт хийж ажилласан байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээ болон Бараа үйлчилгээний бусад зардалд нийт 25,849.5 мянган төгрөг батлагдсанаас 23,788.7 мянган төгрөг буюу 92 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ахмадын тухай хуудийн 14 дүгээр зүйл 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулаагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого зарлагын гүйлгээ байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 463,155.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9,263.1 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй хэмнэлттэй ажилласан байна. Энэ хуулийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалинтай холбоотой зардлаас 70,494.7 мянган

төгрөг, хоол хүнснээс 6,410.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 28,654.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлаас 4,997.6 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгон ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаас ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дугаар цэцэрлэг нь 2024 онд мэдээлбэл зохих 169 мэдээллийн хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байгаа тул шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 568.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн тул цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг шалгахад 100.0 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	568.0	2	568.0	100

Нийт дүн					
----------	--	--	--	--	--

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын даргын -ын 2024 оны 01 сарын 12 өдөр баталсан 464,204.0 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 12 сарын 28 өдөр 210,589.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 87.8 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 891.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 891.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөөгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

5.2 Албан шаардлага

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг зөрчиж Нягтлан бодогч Б.Гоццэцэгт 661.9 мянган төгрөг, нярав Т.Цэцэгээд 229.2 мянган төгрөг, нийт 891.2 мянган төгрөгийн балансын шагнал, үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон нь Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой зөвлөмж өгөх зөрчилтэй асуудал илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Балансын шагнал үр дүн	1	891.2			1	891.2						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

давхардуу лан авсан												
Дүн	1	891.2			1	891.2						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-

ААБ 5.5: АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Шарын гол сумын сумын 19 дүгээр Цэцэрлэг
Тайлант хугацаа: 2024 он

Хүснэгт А. АГАДУТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

№	Нөлөөлж буй АГАДУТ	АГАДУТ-ийн дэд анги	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөж тооцох эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
							Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт					
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Ажил гүйлгээний анги	Цалингийн зардлын данстай холбоотой асуудал	Нягтлан бодогч Б.Гоццэцэгт 661,950.00 төгрөг, нярав Т.Цэцэгээд 229,240.00 төгрөг, нийт 891,190.00 төгрөгийн балансын шагнал, үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон байна.	891,190.00	Тийм	Үгүй	УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга"	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"	Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой	Албан шаардлага хүргүүлэх			
Дүн				891,190.00									

Хүснэгт Б. Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогдолтой биш АГАДУТ-ыг үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

№	Тодорхойлсон эрсдэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөж тооцох эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн	Гаргасан шийдэл
						Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт					
1	Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байх	Тайлант онд батлагдсан төсвөөс ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна.	-	Тийм	Үгүй	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга	Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 1.1, 1.2, 1.3, 2.1.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна.	Хууль тогтоомжийн заалттай холбоотой асуудал.	Зөвлөмж			
Дүн												

Бэлтгэсэн:
Аудитор

Хянасан:

Чанарын хяналтын менежер

Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК-ийн захирал



Танилцаж, зөвшөөрсөн

Б.Хоролбат

огноо:

Л.Магсаржалам

Огноо:

С.Оргил

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дүгээр Цэцэрлэг

Дарга

Б.Саруул

Огноо:

Нягтлан бодогч

Б.Гоццэцэг

Огноо:





**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2025 он 02 сар 25 өдөр

Дугаар 01/МЭ-23720082-ДТН-2025/857НА-ЦМ-ХБ Дархан сум

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цэцэрлэгийн нягтлан бодогч Б.Гоццэцэг, нярав Т.Цэцэгээ нарт улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан нийт 891,190.00 төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж, мөнгөн урамшуулал давхардуулан олгох зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Б.Саруул, нягтлан бодогч Б.Гоццэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

"ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ
АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

С.ОРГИЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Д.МАГСАРЖАЛАМ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ш.МӨНХБАЯР

452504094